



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар АТЦ/

Улаанбаатар хот

Малын тэжээлийг татан авч
иргэдэд олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын нөөцөөс олгосон тэжээлийг татан авах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т, дүүргийн малчин болон мал бүхий иргэдэд тэжээл олгох ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн дотор зохион байгуулахыг дүүргийн Менежер (Г.Дагвадорж)-т тус тус үүрэг болгосугай.

2.Тэжээлийг иргэдэд олгох хуваарийг нэгдүгээр, татан авахад шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах 776,800 (Долоон зуун далан зургаан мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 сарын 10-ны өдрийн 114 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ТЭЖЭЭЛ ОЛГОХ ХУВААРЬ

Д/д	Нэр	Хэмжих нэгж	Олгох тоо хэмжээ	Олгох өрхийн тоо	Олгох хуваарь	Хариуцах албан тушаалтан
1-р хороо						
1	Тэжээл (Баавар)	ширхэг	416	133	2025.04.14	Хөдөө аж ахуйн тасаг, Хорооны ажлын алба
2-р хороо						
2	Тэжээл (Баавар)	ширхэг	384	141	2025.04.14	Хөдөө аж ахуйн тасаг, Хорооны ажлын алба
Нийт дүн			800	274		

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 сарын 10-ны өдрийн 16 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ТЭЖЭЭЛ ТАТАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр		Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Шаардагдах хэмжээ	Нийт үнэ
1	Шатахуун	Түлш	Литр	2390	40	95,600
		Бензин	Литр	2360	170	401,200
2	Хоолны зардал		Хүн/өдөр	14x20,000	280,000	280,000
Нийт						776,800